



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөст сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/133/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.25 № 110
танай _____ -ны № _____ -т

МӨСТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Х.БОЛД-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөст сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтууд, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Түлээ нүүрсний үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй, хагас бүтэн жилээр хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодоогүй, бараа материалын үлдэгдэлд байгаа материалыг бөөн дүнгээр шийдвэргүйгээр зарлагдсан,
- Үнэт цаасны тооцоо бодоогүй,
- Илүү цагаар ажилласныг нотлох анхан шатны баримтгүйгээр илүү цагийн хөлс бодож олгосон,
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй,
- Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй 31.7 сая төгрөг
- Санхүүгийн тайланд авлага, өглөг, үндсэн хөрөнгө, бараа материалыг зөрүүтэй илэрхийлсэн,

- Нягтлан бодогч нь санхүүгийн тайлан программ ашиглах, тайлан гаргах чадваргүй

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Соёлын төв нь нийт соёлын 95 үйлчилгээг 23211 хүн хамруулж, 4 төрлийн хөгжим, дуу, бүжиг дугуйлан хичээллүүлэн 234 суралцагчдыг хамруулан, шинээр гарч буй кино үйлчилгээг сумын иргэдэд үзүүлэх төслийн хүрээнд 3 шинэ кино гаргаж 134 хүнд үйлчилсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд улсын төсвөөс 187.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 24.7 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8.0 сая, нийт 220.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 60.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 8 зорилтын 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлээр 96 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас 93 хувиар тус тус дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	1,984,530.57	370,284.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,924,530.57	310,284.45
335	Бусад авлага	60,000	60,000
33510	Байгууллагаас авах авлага	60,000	60,000
34	УРЬДЧИЛГАА	200,000	200,000
3471	Урьдчилгаа тооцоо	200,000	200,000
34713	Цалингийн урьдчилгаа	200,000	200,000
35	БАРАА МАТЕРИАЛ	23,867,451	33,333,342
351	Түүхий эд материал	-	16,846,000
35110	Тусгай зориулалттай материал	-	16,846,000
354	Хангамжийн материал	23,867,451	16,487,342
35410	Бичиг хэргийн материал	30,000	170,000
35420	Аж ахуйн материал	7,891,751	11,323,642
35440	Түлш, шатах тослох материал	15,565,700	4,613,700
35470	Бусад хангамжийн материал	380,000	380,000
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,051,981.57	33,903,626.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,118,248,368.80	1,116,262,263.22
392	Биет хөрөнгө	1,112,647,467.56	1,111,114,997.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,050,411,992.70	1,050,411,992.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(164,089,374.97)	(181,771,524.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	212,390,896.50	202,149,994.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,921,504.59)	(78,103,871.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,635,793.00	108,753,516.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(44,534,207.73)	(24,688,981.65)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	12,118,900	12,118,900
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,400,000	3,400,000
39215	Хуримтлагдсан элэгдэл	(28,333.35)	(368,333.55)
39217	Ном	14,263,306	19,213,306
393	Биет бус хөрөнгө	5,600,901.24	5,147,265.48
39301	Програм хангамж	1,956,716.00	1,956,716.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(287,014.76)	(459,850.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,212,000	4,212,000
39304	Хуримтлагдсан элэгдэл	(280,800)	(561,600)
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,118,248,368.80	1,116,262,263.22
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,144,300,350.37	1,150,165,889.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,169,256.72	5,279,666.18
413	Өглөг	1,169,256.72	5,279,666.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	191,066.69	1,662,576.15
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	641,190.03	651,190.03
4136	Бусад өглөг	337,000	2,965,900
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,965,900
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	337,000.00	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,169,256.72	5,279,666.18
51	Засгийн газрын хувь оролцоо	1,143,131,093.65	1,144,886,223.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	781,292,388	781,292,388
51101	Өмч: - төрийн	781,292,388	781,292,388
512	Хуримтлагдсан үр дүн	28,175,442.27	29,930,572.11
51210	Өмнөх үеийн үр дүн	(20,072,622.91)	28,251,553.14
51220	Тайлант үеийн үр дүн	48,248,065.18	1,679,018.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	333,663,263.38	333,663,263.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,143,131,093.65	1,144,886,223.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,144,300,350.37	1,150,165,889.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	242,603,341.35	212,539,700
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	219,472,941.35	187,823,900
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	219,472,941.35	187,823,900
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,130,400	24,715,800
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,130,400	24,715,800
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	113,925,430.25	86,600,500
120	Нийтлэг татварын бус орлого	113,925,430.25	86,600,500
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,257,000	8,054,500
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,057,000	8,054,500
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	110,668,430.25	65,450,000
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	13,096,000
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	356,528,771.60	299,140,200
21	УРСГАЛ ЗАРДАЛ	308,280,706.42	288,492,084.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	228,461,545.88	274,416,461.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	136,755,011.37	154,869,277.92
210101	Үндсэн цалин	84,228,754.33	108,832,703.05
210102	Нэмэгдэл	41,776,140.04	31,005,914.60
210104	Урамшуулал	10,750,117	11,089,033
210105	Гэрээт ажлын хөлс	-	3,941,627.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,979,586.02	19,162,076.91
210201	Тэтгэврийн даатгал	11,667,287.82	13,161,316.35
210202	Тэтгэмжийн даатгал	1,301,471.50	1,475,750.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	650,735.69	729,954.99
210204	Ажилгүйдлийн даатгал	646,523.30	729,954.99
210205	Эрүүл мэндийн даатгал	2,713,567.71	3,065,100.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,092,724.89	30,304,773.21
210301	Гэрэл, цахилгаан	2,632,724.89	2,675,373.21
210302	Түлш, халаалт	8,460,000	27,629,400
2104	Хангамж, бараа материалын зардал	9,428,684	9,747,359
210401	Бичиг хэрэг	868,600	1,989,600
210402	Тээвэр, шатахуун	2,868,730	1,496,250
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,050,000	660,000
210404	Ном, хэвлэл	80,000	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,561,354	5,601,509
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,392,000	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	395,000	-
210604	Урсгал засвар	997,000	-
2107	Томилолт, зочны зардал	884,000	640,000
210702	Дотоод албан томилолт	884,000	640,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,527,298	331,854
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,287,298	181,854
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	150,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,240,000	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,402,241.60	59,361,120.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,192,000	68,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,210,241.60	59,293,120.16

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,819,160.54	14,075,623.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,857,000	798,406
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,077,000	798,406
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,962,160.54	13,277,217.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,277,217.54
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	77,962,160.54	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	308,280,706.42	288,492,084.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	48,248,065.18	10,648,115.26
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	8,569,096.29
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	8,569,096.29
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(8,569,096.29)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	48,248,065.18	2,079,018.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	242,603,341.35	212,539,700
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	219,472,941.35	187,823,900
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	219,472,941.35	187,823,900
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,130,400	24,715,800
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,130,400	24,715,800
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	3,257,000	8,054,500
120	Нийтлэг татварын бус орлого	3,257,000	8,054,500
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,257,000	8,054,500
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,057,000	8,054,500
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	245,860,341.35	220,594,200
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,739,002.94	217,344,200
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189,919,842.40	203,268,576.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	138,039,544.58	151,847,104.85
210101	Үндсэн цалин	82,167,190.94	91,082,715.81
210102	Нэмэгдэл	45,241,861.64	47,342,715.99
210104	Урамшуулал	10,630,492	9,639,022.89
210105	Гэрээт ажлын хөлс	-	3,782,650.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,441,798.93	19,098,494.40
210201	Тэтгэврийн даатгал	10,905,231.32	12,790,725.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,284,347.34	1,319,289.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	963,153.26	702,215.59
210204	Ажилгүйдлийн даатгал	663,737.80	1,271,400.36
210205	Эрүүл мэндийн даатгал	2,625,329.21	3,014,862.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,946,724.89	19,109,373.21
210301	Гэрэл, цахилгаан	2,632,724.89	2,675,373.21
210302	Түлш, халаалт	13,050,000	16,434,000
210303	Цэвэр, бохир ус	264,000	-
2104	Хангамж, бараа материалын зардал	5,167,830	2,958,850
210401	Бичиг хэрэг	599,100	300,000

210402	Тээвэр, шатахуун	2,041,130	1,744,250
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,000	660,000
210404	Ном, хэвлэл	80,000	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	497,600	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000	254,600
2105	Нормативт зардал	500,000	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,818,150	5,114,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,621,650	3,514,000
210604	Урсгал засвар	1,196,500	1,600,000
2107	Томилолт, зочны зардал	884,000	640,000
210702	Дотоод албан томилолт	884,000	640,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,740,294	700,854
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,294	550,854
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	150,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,240,000	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,381,500	3,799,900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,381,500	3,799,900
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,819,160.54	14,075,623.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,857,000	798,406
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,077,000	798,406
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,962,160.54	9,270,790.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	9,270,790.75
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	77,962,160.54	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,006,426.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,006,426.79
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	<u>269,739,002.94</u>	<u>217,344,200.00</u>
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(23,878,661.59)</u>	<u>3,250,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,020,000	3,250,000
2200	Дотоод эх үүсвэрээр	11,020,000	3,250,000
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,020,000	3,250,000
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,020,000	3,250,000
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(11,020,000)</u>	<u>(3,250,000)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(34,898,661.59)	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,898,661.59	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	781,292,388	333,663,263.38	-20,072,622.91	1,094,883,028.47
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	781,292,388	333,663,263.38	-20,072,622.91	1,094,883,028.47
C09	Тайлант үеийн үр дүн	-	-	48,248,065.18	48,248,065.18
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,292,388	333,663,263.38	28,175,442.27	1,143,131,093.65
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	781,292,388	333,663,263.38	28,175,442.27	1,143,131,093.65
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	76,110.87	76,110.87
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	781,292,388	333,663,263.38	28,251,553.14	1,143,207,204.52
C19	Тайлант үеийн үр дүн	-	-	2,079,018.97	2,079,018.97
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,292,388	333,663,263.38	30,330,572.11	1,145,286,223.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
12200	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	242,085,400	199,762,482.46
122005	Төсвөөс санхүүжих	242,085,400	199,762,482.46
12000	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	-	7,554,500
120004	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	7,554,500
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	242,085,400	207,316,982.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	246,085,400	207,316,982.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	245,083,000	206,518,576.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,647,900	151,847,104.85
210101	Үндсэн цалин	109,958,400	91,082,715.81
210102	Нэмэгдэл	60,477,200	47,342,715.99
210104	Урамшуулал	10,212,300	9,639,022.89
210105	Гэрээт ажлын хөлс	-	3,782,650.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,581,000	19,098,494.40
210201	Тэтгэврийн даатгал	15,390,700	12,790,725.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,797,600	1,319,289.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	898,800	702,215.59
210204	Ажилгүйдлийн даатгал	898,800	1,271,400.36
210205	Эрүүл мэндийн даатгал	3,595,100	3,014,862.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,115,800	19,109,373.21
210301	Гэрэл, цахилгаан	1,515,800	2,675,373.21
210302	Түлш, халаалт	21,600,000	16,434,000
2104	Хангамж, бараа материалын зардал	2,810,200	2,958,850
210401	Бичиг хэрэг	360,000	300,000
210402	Тээвэр, шатахуун	1,300,000	1,744,250
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000	660,000
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,200	254,600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,273,200	5,114,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,673,200	3,514,000
210604	Урсгал засвар	1,600,000	1,600,000
2107	Томилолт, зочны зардал	750,000	640,000
210702	Дотоод албан томилолт	750,000	640,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,900,000	3,200,854
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	4,750,000	3,050,854

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000	150,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,004,900	4,549,900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,004,900	4,549,900
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,002,400	798,406
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,002,400	798,406
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,002,400	798,406
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	246,085,400	207,316,982.46

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 189,487.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 180,168.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгө данснаас тусгай зориулалтын материал руу шилжүүлсэн урлагийн хувцас, хэрэгсэл, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг нийт 97,4781.8 мянган төгрөгөөр дутуу,
- Бараа материалын 35420, 35440 дансны материалыг өмнөх оны материалын зөрүү гэсэн утгаар 8,641.0 мянган төгрөгийн хөрөнгийг зарлагадсан, 18,046.0 мянган төгрөгийн хөрөнгөөс шилжиж ирсэн урлагийн хувцсыг орлогод аваагүй,
- Авлагыг 1,042.4 мянган төгрөгөөр дутуу,
- Өр төлбөрийг 276.4 мянган төгрөгөөр зөрүүтэй,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүнг 41,404.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд оны эцэст улс болон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн 13,277.2 мянган төгрөгөөр тохируулах бичилтийг орхигдуулсан,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 9,318.7 мянган төгрөгийн 4 зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 9,318.7 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс, 2,070.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 7,248.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Илүү цагийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Соёлын төвийн эрхлэгч нь тухайн саруудад ямар ажлыг илүү цагаар ажилласан эсэх нь тодорхойгүй, нотлох анхан шатны баримтгүй цагийн нэмэгдэл 2,070,000 төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт 4-т “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно” эсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Үнэт цаасны тооцоо бодолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогыг данс бүртгэлд төвлөрүүлсэн ч хэдэн хэдний өдрүүд ямар урлаг уран бүтээлийн тоглолт хийж хэчнээн тасалбар зарцуулсан эсэх нь тодорхойгүй нотлох анхан шатны баримтгүй үнэт цаасны тооцоо бодоогүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Үнэт цаасны тооцоог бодож хэвших

3.2.2 Тооллого хийхтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын 35440 дансанд түлшний үлдэгдлийг 2022 оны санхүүгийн тайланд ямар бараа материал байгаа эсэх тодорхойгүй бөөн дүнгээр тусгасан, тайлант онд худалдан авсан 27 нэр төрлийн 533.0 мянган төгрөгийн бараа материалыг тоо ширхэг, нэг бүрийн үнийг сольж бүртгэн орлогод авч, зарлага гаргасан, оны эцэст түлээ нүүрсэнд тооллого хийгээгүй хэчнээн тонн түлээ нүүрс байгаа эсэх нь тодорхойгүй, 30 тонн нүүрсний үлдэгдлийг зарцуулснаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;”, 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн тооллого, түүний хугацаа, 70. 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/; гэж заасантай нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлан гарахаас өмнө бараа материалын тооллогыг хийж хэвших, бараа материалын үлдэгдэлд бөөн дүнгээр бүртгэсэн 3,415.7 мянган төгрөгийн түлшний үлдэгдлийг өмнө оны анхан шатны баримтаас хөөн 2026 оны эхний хагаст багтаан ямар бараа материалын үлдэгдлээр байгааг баталгаажуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын

төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөст сумын Соёлын төв	7	180,168.8	4	125,487.5	3	54,681.3	7	180,168.8	-	-	-	-
Дүн	7	180,168.8	4	125,487.5	3	54,681.3	7	180,168.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөст сумын Соёлын төв	3	9,318.7	1	2,070.0			2	7,248.7	-	-	-	-
Дүн	3	9,318.7	1	2,070.0	-	-	2	7,248.7	-	-	-	-

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	-	1	-	-
НИЙТ			1	-	-	-	1	-	-